

Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрөл сунгах, шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.5, 16 дугаар зүйлийн 16.3.4, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Ажлын хэсгийн саналыг үндэслэн тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгах 3 /гурав/, шинээр олгох 2 /хоёр/, нийт 5 аж ахуйн нэгж, иргэдийн нэрсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгж, иргэдийн тамхи худалдах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс /Д.Булган/, Мэргэжлийн хяналтын хэлтэс /Д.Хишигбаатар/, Цагдаагийн 1 дүгээр хэлтэс /Ө.Эрдэнэхүү /, Цагдаагийн 2 дугаар хэлтэс /Д.Сүрэн/, хороодын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсэг /А.Дамцагдорж/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ